**ЗАГВАР 10: АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ЗАГВАР**

## ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан АЗЗА" ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДАА-2023/14/НА-СА-ТӨА**


Цахим хуудас: www.audit.mn
Дархан-Уул аймаг
2022 он

Тэргүүлэх аудитор: **Ш.Мөнхбаяр**
Утас: **7037-3089**
Цахим хаяг: m**unkhbayarsh@audit.gov.mn**
Ахлах аудитор: **С.Батцэцэг**
Утас: **7037-3089**
Цахим хаяг: battsetsegs**@audit.gov.mn**
Аудитор: **Б.Алтанзул**
Утас: **7037-3089**
Цахим хаяг: Altanzulby**@audit.gov.mn**


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт** /Баталгаажсан хувийг оруулах/

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2023.04.15 № 159

"ДАРХАН АЗЗА" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БАЯСГАЛАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дархан АЗЗА" ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Дархан АЗЗА" ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, аргачлалын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон зүйл**

ТӨБЗГ-ын 2022 оны 337 дугаар тогтоол, Компанийн гүйцэтгэх захирлын 2022 оны 63 дугаар тушаалаар ажилчдын цалингийн хэмжээг 30 хувиар нэмж шинэчлэн тогтоожээ.

**Аудитын гол асуудлууд**

Тайлант онд ТӨБЗГ-ын 2022 оны 141 дугаар тогтоолоор ТУЗ-ын хараат бус 3 гишүүдийг шинэчлэн томилсон.

**Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн жилийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 44 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 96.9 хувиар тайлагнасныг Зам тээврийн хөгжлийн яамнаас 96.5 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

000020247

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэх болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгч-дийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.МӨНХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Мөрний дугаар | Балансын зүйл | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | **-** | **-** |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | **-** | **-** |
| 1.1.01 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 14,114,097.44 | 8,300,179.34 |
| 1.1.02 | Дансны авлага | 304,820,245.93 | 482,822,491.87 |
| 1.1.03 | Татвар, НДШ-ийн авлага | - | 14,985,658.80 |
| 1.1.04 | Бусад авлага | 989,974.90 | 1,371,787.14 |
| 1.1.06 | Бараа материал | 406,602,183.26 | 418,008,665.03 |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **726,526,501.53** | **925,488,782.18** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | **-** | **-** |
| 1.2.01 | Үндсэн хөрөнгө | 925,709,457.17 | 1,026,115,160.20 |
| 1.2.02 | Биет бус хөрөнгө | 488,924,848.54 | 487,830,909.16 |
| 1.2.03 | Биологийн хөрөнгө | 3,165,000.00 | 2,075,000.00 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 1,417,799,305.71 | 1,516,021,069.36 |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,144,325,807.24** | **2,441,509,851.54** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **-** | **-** |
| 2.1 | Өр төлбөр | - | - |
| **2.1.1** | **Богино хугацаат өр төлбөр** | **-** | **-** |
| 2.1.1.01 | Дансны өглөг | 115,923,399.54 | 270,627,552.54 |
| 2.1.1.02 | Цалингийн өглөг | - | - |
| 2.1.1.03 | Татварын өр | 58,221,978.09 | 164,031,899.47 |
| 2.1.1.04 | НДШ - ийн өглөг | 64,367,791.51 | 132,420,614.00 |
| 2.1.1.05 | Богино хугацаат зээл | 2,008,777.67 | 2,045,458.41 |
| 2.1.1.08 | Урьдчилж орсон орлого | 17,439,000.00 | 17,439,000.00 |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **257,960,946.81** | **586,564,524.42** |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | - | - |
| 2.1.2.01 | Урт хугацаат зээл | 812,472,334.00 | 812,472,334.00 |
| 2.1.2.02 | Нөөц /өр төлбөр/ | - | - |
| **2.1.2.06** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **812,472,334.00** | **812,472,334.00** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **1,070,433,280.81** | **1,399,036,858.42** |
| 2.3 | Эздийн өмч | - | - |
| 2.3.01 | Өмч: - төрийн | 582,966,824.33 | 582,966,824.33 |
| 2.3.02 | - хувийн | - | - |
| 2.3.03 | - хувьцаат | - | - |
| 2.3.05 | Нэмж төлөгдсөн капитал | - | - |
| 2.3.06 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 134,917,715.01 | 169,381,142.45 |
| 2.3.07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | - | - |
| 2.3.08 | Эздийн өмчийн бусад хэсэг | 704,928,568.65 | 704,928,568.65 |
| 2.3.09 | Хуримтлагдсан ашиг | (348,920,581.56) | (414,803,542.31) |
| 2.3.09.1 | Тайлангийн үеийн ашиг | 5,015,805.55 | (65,882,960.75) |
| 2.3.09.2 | Өмнөх үеийн ашиг | (353,936,387.11) | (348,920,581.56) |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **1,073,892,526.43** | **1,042,472,993.12** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **2,144,325,807.24** | **2,441,509,851.54** |

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Балансын зүйл | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **01** | **Борлуулалтын орлого (цэвэр)** | **1,547,494,153.09** | **1,712,121,306.36** |
| **02** | **Борлуулалтын өртөг** | **1,316,471,285.21** | **1,545,850,712.93** |
| **03** | **Нийт ашиг( алдагдал)** | **231,022,867.88** | **166,270,593.43** |
| 04 | Түрээсийн орлого | - | - |
| 05 | Хүүний орлого | - | - |
| 06 | Ногдол ашгийн орлого | - | - |
| 07 | Эрхийн шимтгэлийн орлого | - | - |
| 08 | Бусад орлого | 1,115,909.09 | 5,406,977.08 |
| **08.1** | **Орлогын дүн** | **1,115,909.09** | **5,406,977.08** |
| 09 | Борлуулалт, маркетингийн зардал | - | - |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 204,261,872.96 | 212,679,518.97 |
| 11 | Санхүүгийн зардал | 12,623,886.73 | 10,416,737.38 |
| 12 | Бусад зардал | - | - |
| **12.1** | **Зардлын дүн** | **216,885,759.69** | **223,096,256.35** |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | - | - |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | - | - |
| 17 | Бусад ашиг ( алдагдал) | (9,679,900.00) | (14,464,274.91) |
| 17.1 | Олз, гарзын дүн | (9,679,900.00) | (14,464,274.91) |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)** | **5,573,117.28** | **(65,882,960.75)** |
| 19 | Орлогын татварын зардал | 557,311.73 | - |
| 2.1.2.6 | 05-Бусад орлого | - | - |
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **5,015,805.55** | **(65,882,960.75)** |
| 21 | Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал) | - | - |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **5,015,805.55** | **(65,882,960.75)** |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| 23.3 | Бусад олз (гарз) | - | - |
| 24 | Орлогын нийт дүн | - | - |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | - | - |

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Өмч | Нэмж төлсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| 01 | 2020 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл | 582,966,824.33 | - | 134,917,715.01 | 694,590,427.65 | (353,936,387.11) | 1,058,538,579.88 |
| 02 | НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга | - | - | - | - | - | - |
| 03 | Залруулсан үлдэгдэл | - | - | - | - | - | - |
| 04 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | 5,015,805.55 | 5,015,805.55 |
| 05 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - | - |
| 06 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | 10,338,141.00 | - | 10,338,141.00 |
| 07 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - | - |
| 08 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - | - | - |
| 09 | 2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл | 582,966,824.33 | - | 134,917,715.01 | 704,928,568.65 | (348,920,581.56) | 1,073,892,526.43 |
| 10 | НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга | - | - | - | - | - | - |
| 11 | Залруулсан үлдэгдэл | - | - | - | - | - | - |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | (65,882,960.75) | (65,882,960.75) |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - | - |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - | - | - |
| 15 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - | - |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | 34,463,427.44 | - | - | 34,463,427.44 |
| 17 | 2022 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл | 582,966,824.33 | - | 169,381,142.45 | 704,928,568.65 | (414,803,542.31) | 1,042,472,993.12 |

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **-** | **-** |
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **1,874,640,485.00** | **1,731,583,152.61** |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 1,672,794,664.00 | 1,654,635,426.17 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | - | - |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 120,282.00 | |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | - | 116,000.00 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 201,725,539.00 | 76,831,726.44 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **1,971,481,893.38** | **1,569,897,070.71** |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 354,097,605.64 | 346,606,712.71 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 44,005,584.01 | 35,859,909.12 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 593,209,551.22 | 470,429,714.00 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 9,172,674.51 | 8,778,872.49 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн | 215,955,706.80 | 466,265,807.01 |
| 1.2.6 | Хүүний төлбөрт төлсөн | 11,777,845.08 | 9,752,697.59 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 165,529,791.52 | 157,628.00 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 3,072,228.00 | 114,750.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 574,660,906.60 | 231,930,979.79 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (96,841,408.38) | 161,686,081.90 |
| **2** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **-** | **-** |
| **2.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **6,000,000.00** | **-** |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 6,000,000.00 | - |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **7,282,000.00** | **165,000,000.00** |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 7,282,000.00 | 165,000,000.00 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(1,282,000.00)** | **(165,000,000.00)** |
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **-** | **-** |
| **3.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **-** | **-** |
| **3.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **1,523,020.00** | **(2,500,000.00)** |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | 1,523,020.00 | 2,500,000.00 |
| **3.3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(1,523,020.00)** | **(2,500,000.00)** |
| **4** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(99,646,428.38)** | **(5,813,918.10)** |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 113,760,525.82 | 14,114,097.44 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 14,114,097.44 | 8,300,179.34 |

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2021 оны гүйцэтгэл | Зөрүү | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| Үйлчилгээний орлого | 628,895,800.00 | 700,000,000.00 | 746,356,384.50 | 46,356,384.50 | 106.6 |
| Борлуулалтын орлого | 917,346,600.00 | 764,768,000.00 | 963,225,367.30 | 198,457,367.30 | 126.0 |
| Эрчмийн орлого | 1,251,600.00 | - | 2,444,118.20 | 2,444,118.20 | |
| Үйл ажиллагааны бус бусад орлого | 1,115,900.00 | - | 5,502,431.60 | 5,502,431.60 | |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 1,548,609,900.00 | 1,464,768,000.00 | 1,717,528,301.60 | 252,760,301.60 | 117.3 |
| Бусад орлого | - | - | - | - | |
| НИЙТ ОРЛОГЫН ДҮН | **1,548,609,900.00** | **1,464,768,000.00** | **1,717,528,301.60** | **252,760,301.60** | 117.3 |
| Цалин хөлс | 419,306,731.27 | 545,686,080.00 | 393,933,527.20 | (151,752,552.80) | 72.2 |
| Материалын зардал | 444,676,203.83 | 459,503,700.00 | 988,717,507.81 | 529,213,807.81 | 215.2 |
| Ашиглалтын зардал | 7,314,485.25 | 12,064,000.00 | 8,026,498.42 | (4,037,501.58) | 66.5 |
| Засвар үйлчилгээний зардал | 18,042,056.73 | 3,270,000.00 | 9,346,275.27 | 6,076,275.27 | 285.8 |
| Ажиллагсадтай холбоотой зардал | 10,727,384.55 | 78,201,100.00 | 46,857,638.29 | (31,343,461.71) | 59.9 |
| Элэгдлийн зардал | 184,302,436.32 | 171,350,000.00 | 85,151,663.79 | (86,198,336.21) | 49.7 |
| Тээврийн зардал | 66,004,607.82 | 16,800,000.00 | 122,834,852.14 | 106,034,852.14 | 731.2 |
| Татвар даатгал төлбөр хураамжийн зардал | 148,208,147.22 | 15,010,700.00 | 272,378.00 | (14,738,322.00) | 1.8 |
| ТУЗ-ийн зардал | 44,231,155.15 | 47,011,500.00 | 44,862,162.24 | (2,149,337.76) | 95.4 |
| Бусад зардал | 206,223,574.58 | 97,371,100.00 | 83,408,741.03 | (13,962,358.97) | 85.7 |
| НИЙТ ЗАРДЛЫН ДҮН | **1,549,036,782.72** | **1,446,268,180.00** | **1,783,411,244.19** | **337,143,064.19** | 123.3 |
| ОЛЗ ГАРЗЫН ДҮН | 6,000,000.00 | - | - | - | |
| НИЙТ АШИГ/АЛДАГДАЛ | **5,573,117.28** | **18,499,820.00** | **(65,882,942.59)** | **(84,382,762.59)** | (356.1) |

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Аудитаар нийт 283,371.8 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад ТӨБЗГ-ын 2022 оны 644 тоот тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 10 нэр төрлийн 283,371.8 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаагүй байсныг залруууллаа.

Үүнд: ТӨБЗГ-ын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 644 дүгээр тогтоолоор 283,371.8 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлж бүртгэсэн боловч анхны өртөг, хуримтлагдсан элэгдлийг данснаас хасаагүй байв.

Аудитаар нийт 24,550.9 төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 1,803.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 22,747.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 14,660.6 мянган төгрөгийн зөрчлийг шинж чанарын хувьд материаллаг бус гэж үзсэн бөгөөд, залруулагдаагүй 9,890.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдал 21,443.2 мянган төгрөгөөс 11,553.1 мянган төгрөгөөр бага байгаа тул "Зөрчилгүй" дүгнэлт өглөө.

**3.1 Төлбөрийн акт**

**3.1.1** Тайлант онд 4 ажилтанд ээлжийн амралтын хугацаанд 1,227.0 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1.-д "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно" гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

**3.1.2** 2021 оны санхүүгийн тайлангаар аудитаар тогтоосон 280.0 мянган төгрөгийн төлбөрийг актыг байгууллагын хөрөнгөөр барагдуулсан нь ТБОНӨТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.2 "*төрийн өмчит хуулийн этгээдийн өөрт олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг энэ хуульд нийцүүлэн тогтоох*" гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

**3.1.3** Үнэлгээний хорооны даргаар ажилласан хүнд буудлын хөлс 266.5 мянга, мөн замын хашлага суурилуулсан ажилтнуудын хувийн хэрэгцээний зардалд 30.0 мянга, нийт 296.5 мянган төгрөгийг байгууллагын зардлаас төлсөн нь ТБОНӨТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.2 "*төрийн өмчит хуулийн этгээдийн өөрт олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг энэ хуульд нийцүүлэн тогтоох*" гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

**3.2 Албан шаардлага**

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.3.1. ***Шилэн дансны хуультай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Тайланд онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 14,660.6 мянган төгрөгийн 14 шийдвэрийг мэдээлээгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасны дагуу хугацаанд нь байршуулж ажиллах.

3.3.2. Зардалтай холбоотой асуудал

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

Улсын чанартай авто замын гүүрний арчлалт, засвар үйлчилгээг гүйцэтгэх тусгай зөвшөөрөлгүй компаниар гүйцэтгүүлсэн нь Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д ”Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд холбогдох хууль, журмын дагуу захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Улсын чанартай авто замын гүүрний арчлалт, засвар үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэй компаниар гүйцэтгүүлэх,

*2.2. <u>Илрүүлэлт:</u>*

Байгууллага, хувь хүмүүстэй байгуулсан ажил гүйцэтгүүлэх гэрээний үнэ тарифт тогтоосон норм, жишиг үнийг баримтлаагүй нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 256 дугаараар баталсан *“Норм батлах тухай”* тушаалын 3,4 дүгээр хавсралттай нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Байгууллага, хувь хүмүүстэй байгуулсан ажил гүйцэтгүүлэх гэрээний үнэ тарифт тогтоосон норм, жишиг үнийг баримтлах,

*2.3. <u>Илрүүлэлт:</u>*

Тайлант онд улсын чанартай авто зам, замын байгууламжид арчлалт, засварын ажлыг гүйцэтгэхдээ захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гэрээний дүнгийн 19.5 хувиар туслан гүйцэтгэгч ажиллуулахаар гэрээ байгуулсан байна. Энэ нь Зам тээврийн хөгжлийн яамтай байгуулсан "Улсын чанартай авто зам, замын байгууламжид 2022 онд арчлалт, засварын ажил гүйцэтгэх гэрээ"-ний 3 дугаар зүйлийн 3.12-т ”Гүйцэтгэгч нь гэрээт ажлын 10 хүртэлх хувьд туслан гүйцэтгэгч ажиллуулж болох бөгөөд хэтэрсэн тохиолдолд захиалагчаас заавал зөвшөөрөл авах бөгөөд зөвшөөрөлгүйгээр ажиллуулсан тохиолдолд туслан гүйцэтгэгч, гэрээт ажилтны хийж гүйцэтгэсэн ажлын 10 хувиар торгууль ногдуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Зам тээврийн хөгжлийн яамтай байгуулсан "Улсын чанартай авто зам, замын байгууламжид арчлалт, засварын ажил гүйцэтгэх гэрээ"-г мөрдөж ажиллах

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ТӨБЗГ-ын 2022 оны 644 тоот тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 10 нэр төрлийн 283,371.8 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаагүй байсан. | 1 | 283,371.8 | - | - | 1 | 283,371.8 | 1 | 283,371.8 | - | - | - | - |
| Дүн | 1 | 283,371.8 | - | - | 1 | 283,371.8 | 1 | 283,371.8 | - | - | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант онд 4 ажилтанд ээлжийн амралтын хугацаанд 1,227.0 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон | 1 | 1,227.0 | 1 | 1,227.0 | - | - | - | - | - | - | - | - |
| 2021 оны санхүүгийн тайлангаар аудитаар тогтоосон 280.0 мянган төгрөгийн төлбөрийг актыг байгууллагын хөрөнгөөр барагдуулсан | 1 | 280.0 | 1 | 280.0 | - | - | - | - | - | - | - | - |
| Үнэлгээний хорооны даргаар ажилласан хүнд буудлын хөлс 266.5 мянга, мөн замын хашлага суурилуулсан ажилтнуудын хувийн хэрэгцээний | 1 | 296.5 | 1 | 296.5 | - | - | - | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| зардалд 30.0 мянга, нийт 296.5 мянган төгрөгийг байгууллагын зардлаас төлсөн | | | | | | | | | | | | |
| Байгууллага, хувь хүмүүстэй байгуулсан ажил гүйцэтгүүлэх гэрээний үнэ тарифт тогтоосон норм, жишиг үнийг баримтлаагүй | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Улсын чанартай авто замын гүүрний арчлалт, засвар үйлчилгээг гүйцэтгэх тусгай зөвшөөрөлгүй компаниар гүйцэтгүүлсэн | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Тайлант онд улсын чанартай авто зам, замын байгууламжид арчлалт, засварын ажлыг гүйцэтгэхдээ захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гэрээний дүнгийн 19.5 хувиар туслан гүйцэтгэгч ажиллуулахаар гэрээ байгуулсан байна. | 1 | 8,086.6 | - | - | - | - | 1 | 8,086.6 | - | - | - | - |
| Дүн | 6 | 9,890.1 | 3 | 1,803.5 | - | - | 3 | 8,086.6 | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 14,660.6 мянган төгрөгийн 14 шийдвэрийг мэдээлээгүй | 1 | 14,660.6 | - | - | - | - | 1 | 14,660.6 |
| Дүн | 1 | 14,660.6 | - | - | - | - | 1 | 14,660.6 |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| | - | - | - | - | - | - | - | - |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - |
| Нийт дүн | 1 | 14,660.6 | - | - | - | - | 1 | 14,660.6 |